

Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 6 дугаар сарын байдлаар)

**I. Нийгмийн байдал**

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 6 дугаар сард 309 байгаагийн 174 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 123 буюу 28.5 хувиар буурч, өмнөх сарынхаас 6 буюу 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эхний 6 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 83 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх сараас 13 буюу 18.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 88 буюу 51.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн хэлтсээр эхний 6 сард 25 иргэн ажилд зуучлуулсны 17 нь буюу 68.0 хувь эмэгтэйчүүд байлаа. Ажил хайгч иргэдийн 48.8 хувийг бүрэн дунд, 17.2 хувийг дипломын болон бакалаврын, 13.5 хувийг техникийн болон мэргэжлийн, 8.2 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.9 хувийг суурь, 3.7 хувийг бага боловсролтой, 1.7 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

**II. Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 6 дугаар сард 3663.6 сая төгрөг, зарлага 4805.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 379.8 сая төгрөг буюу 9.4 хувиар буурч, зарлага 239.6 сая төгрөг буюу 5.2 хувиар өслөө. Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 6 сард 3806 хүнд 676.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 413 хүн буюу 12.2 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 22.1 сая төгрөг буюу 3.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 6 сард 1180 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 14 хүн буюу 1.2 хувиар буурсан, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 13.5 сая төгрөг буюу 3.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2016 оны эхний 6 сард 2626 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 427 хүн буюу 19.4 хувиар өссөн, олгосон халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 8.5 сая төгрөг буюу 3.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**III. Эрүүл мэнд**

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 6 сарын байдлаар 228 эх амаржиж 2015 оны мөн үетэй харьцуулахад 19 буюу 8.3 хувиар төрөлт нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 229 үүнээс 105 нь хүү, 124 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 19 буюу 8.3 хувиар, төрсөн хүүхэд 20 буюу 9.6 хувиар тус тус өссөн байна.

**IV. Гэмт хэрэг**

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 6 сард 114 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 11 буюу 10.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Илрээгүй гэмт хэргийн тоо 18, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 70 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 1 буюу 5.9 хувиар өссөн, илрүүлэлтийн хувь 6.5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 97 хүн гэмтэж, 13 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 38 буюу 28.1 хувиар буурсан, нас баралт өмнөх оны мөн үетэй ижил төвшинд байна.

**Хэрэглээний үнийн индекс**

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 5.9 хувь, өмнөх оны эцсийнхээс 3.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар өссөн байна.

**VI. Орон нутгийн төсөв**

2016 оны эхний 6 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 8130.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 7997.6 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 1811.8 сая төгрөг буюу 29.3 хувиар өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 8356.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 7018.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 1338.8 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 807.4 сая төгрөг буюу 13.0 хувиар өссөн байна. 2016 оны эхний 6 сарын байдлаар авлагын үлдэгдэл 19.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 553.2 сая төгрөг байна.

VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлтэгч малын 150598 буюу 88.0 хувь нь 2016 оны 6 дугаар сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 92.0 хувь, эм ямаа 86.3 хувь, үнээний 76.7 хувь, ингэний 51.6 хувь, гүүний 66.8 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 148449 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 19150 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. 2016 оны эхний 6 сард том малын зүй бус хорогдол 11399 болж, өмнөх оны мөн үеийнхээс 10672 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 2 мал, хорогдсон хээлтэгч 3597 байна.

**VIII. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 6 сард нийт гаргалт нь 20526.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4399.5 сая төгрөг буюу 27.3 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 4383.7 сая төг буюу 29.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 20192.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 981.3 сая төгрөг буюу 5.1 хувиар өслөө. Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 19129.1 сая төг буюу 94.7 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.

Материал бэлтгэсэн: Гэрээт ажилтан.....Ү.Содномпил